

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Багш сонгон шалгаруулах хуралд оролцоод 3 долоо хоногийн дараа Монголд сургуульдаа буцаж ирэхэд надад сайхан байна. Ирэх жил сургуульд ажиллах зарим багш нарыг ажилд авсан. Гэхдээ бидэнд нэмж багш авах ажлын байр хэд хэд байна. Олон багш нар Монгол орон, Улаанбаатар хот болон ОУДС-ийн талаар сонирхож байсанд би их баяртай байлаа.

Цагаан Сарын Өдөрлөг амжилттай сайхан болж өнгөрсөн гэж би сонссон. Хэдийгээр би Цагаан Сараар монголд байгаагүй ч Цагаан Сарын Өдөрлөгийн бичлэгийг нь үзэх болно. Цагаан Сарын уламжлалт энэ арга хэмжээг амжилттай зохион байгуулж сайхан тоглолт хийсэн Цагаан Сарын комисст ажилласан багш Эрдэнэцэцэг, Ариунжаргал, Ө. Туул, Цацрал, Болдбаатар нарт талархал илэрхийлье! Та бүхэн сургууль дээр ирэхдээ эдгээр багш нарт баяр хүргэж талархал илэрхийлээрэй.

Би та бүхнээс болон танай жолооч нараас машины зогсоол дээр хурд тохируулж болгоомжтой явахыг дахин хүсье. Машин зогсоолд бүрэн байраа эзэлсэн үед л сурагчид машинаас буух ёстой. Энэ бол сурагчдын аюулгүй байдлыг хангах хамгийн чухал асуудал мөн. Та бүхэн энэ мэдээллийг гэр бүлийхэндээ дамжуулаарай.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

2 сарын 23	ЭББ-ийн хурал номын санд орой 7:00 цагт
3 сарын 3	10-р ангийн сурагчдын бие даасан ажлын тайлан хамгаалалт
3 сарын 5	Бага Сургуулийн сурагчид кино үзнэ
3 сарын 18	Бага Сургуулийн Сурагчдын Жүжигчилсэн Тоглолт

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Та бүхэн Цагаан Сарын Баяраа сайхан тэмдэглэсэн гэдэгт би итгэлтэй байна. Одоо эргээд хичээл сурлагандаа анхаарах цаг боллоо. Та бүхэн хүүхдүүдээ дэмжиж хичээлдээ анхаарал хандуулахад нь туслаарай.

Сурагчид толгой, гэдэс өвдлөө гэж сувилагч дээр ирэх нь их боллоо гэж манай сувилагч хэлсэн. Цаг агаар хуурайшилттай байгаа энэ үед та бүхэн хүүхдүүддээ ус сайн ууж байхыг сануулаарай. Ингэснээр тэдэнд шингэн дутагдахгүй, дээрх зовирууд илрэхгүй байх болно.

Өнөөдөр 2 сарын 19-ний Баасан гарагт 10-р ангийн бүх сурагчид бие дааж хийсэн ажлын тайлангаа өгч дууссан байх ёстой. 3 сарын 3-ны Лхагва гарагт Сурагчдын Тайлан хамгаалалт болно. Энэ өдрийг та бүхэн хуанлидаа тэмдэглээрэй. Танай хүүхдүүд 9 ба 10-р ангид сурдаг бол та бүхэн заавал ирж энэ тайлан хамгаалалтыг үзээрэй. Энэ өдөр сурагчид маань бие дааж хийсэн ажлаа эцэг эхчүүд, найз нөхөд болон багш нартаа тайлагнадаг бөгөөд хүрэлцэн ирсэн хүмүүс их зүйлийг сурч авдаг.

Би гадагшаа явж MAP-ийн сургалтанд суугаад ирэх долоо хоногийн Лхагва гарагт буцаж ирнэ. Сурагчдын мэдлэгийг компьютерээр үнэлэх энэ системийг манай сургууль энэ хичээлийн жилээс эхэлж хэрэгжүүлж байгаа бөгөөд бид өөрсдөө сургалтанд хамрагдаж багш нартаа тусалж сургалт явуулсанаар сурагчдад илүү сайн мэдлэг олж авахад нь туслах болно.

**Дунд Сургуулийн Эрхлэгч
Betsy Hanselmann**

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Та бүхэн гэр бүлийхэнтэйгээ Цагаан Сарын Баяраа сайхан тэмдэглэсэн гэдэгт би итгэлтэй байна.

3 сарын 18 - ны Пүрэв Гараг-Charlie and the Chocolate Factory

Лхагва гарагт хичээлийн дараа жүжгийн бэлтгэл ажилд тусалж байгаа эцэг эхчүүддээ баярлалаа. Хүүхдүүддээ жүжгийн үгээ давтаж цээжлэхэд нь тусалж байгаа эцэг эхчүүддээ бас баярлалаа.

3-р улирлын дугуйлангууд хуваарийн дагуу явагдаж байна. Сурагчид өөрсдийн бүртгүүлсэн дугуйландаа таслахгүй явах хэрэгтэй. Хэрвээ хүүхэд тань дугуйландаа явах боломжгүй буюу эсвэл дугуйлангаас гарах хүсэлтэй бол энэ тухайгаа бидэнд бичгээр ирүүлнэ үү.

3 сарын 5-ны Баасан гарагт бага сургуулийн сурагчид кино үзнэ. Энэ талаарх мэдээллийг ирэх долоо хоногт явуулна.

**Бага Сургуулийн Эрхлэгч
Jan Wiggins**

БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

7-р ангийн сурагчид яаралтай үед анхны тусламж үзүүлэх талаар сурч байгаа. Хичээлийн үеэр тэд хэт даарсан, ухаан алдсан, шархдаж зүсэгдсэн үед хэрхэн анхны тусламж үзүүлэх талаар суралцаж байна. Сурсан зүйлээ практикт хэрэгжүүлж өнгөрсөн долоо хоногийн Мягмар гарагт Tom, Will нэртэй хоёр манеканыг сургууль дээрээ авчирч туршилт хийлээ. Амь нас нь хутганы ирэн дээр байсан Tom, Will хоёрт манай сурагчид анхны тусламж үзүүлж аюултай байдлаас олон удаа аварлаа.

6, 7, 8-р ангийн сурагчид 80 минутын Амьсгал Зүрх Судасны сэхээн амьдруулах сургалтанд хамрагдлаа. Энэ сургалтын үеэр сурагчид DR.ABC зарчмаар аюул байгаа эсэхийг эхэлж нягтлаад хохирогч хариу үйлдэл үзүүлж байгаа эсэхийг шалгана. Хариу үйлдэл үзүүлээгүй тохиолдолд амьсгалын зам болон амьсгалж буй эсэхийг шалгах бөгөөд хохирогчид амьдын шинж тэмдэг илрэхгүй байх тохиолдолд Амьсгал Зүрх Судасны сэхээн амьдруулах арга хэмжээг хэрхэн авах талаар суралцлаа. Одоо сурагчид маань Түргэн тусламж ирэх хүртэл хэрхэн 2 хиймэл амьсгал өгч, 30 удаа зүрхэнд даралтат массаж хийх талаар мэддэг болсон. Сурагчид хичээлийн үеэр олж авсан энэхүү мэдээллээ хэрэглэх шаардлага тэр бүр тохиолдохгүй байх гэдэгт бид найдаж байна.

Манай бусад сурагчид болон эцэг эхчүүд та бүхнийг бид Анхны Тусламж Үзүүлэх сургалтанд хамрагдахыг уриалж байна. Ингэснээр та бүхэн яаралтай тохиолдол гарахад анхны тусламж үзүүлэхэд бэлтгэгдсэн байх болно. Tom, Will хоёрыг сургалтанд хэрэглэхэд тусалсан SOS клиникийн хамт олонд талархал илэрхийлье.

Биеийн Тамирын багш Ms. Lohman